Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 3, № 1(287): 120-126 (2007)

“ЗАД”|ХЭМЭЭХ ҮГИЙН ГАРВАЛ, ТҮҮГЭЭР ДАМЖИН ИЛРЭХ ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН ЕРТӨНЦИЙГ ҮЗЭХ ҮЗЭЛ

Ю.БОЛДБААТАР

ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Сургууль Түүх, хүн судлалын баг
e-mail: bold@must.edu.mn

Түлхүүр үг: *Зад, яд, задын чулуу, тэнгэр, огторгуй, тэнгэр задрах, сүсэг бишрэл, говийн үлдэц – нуклеус, үгийн гарвал, утга, ертөнцийг үзэх үзэл, ертөнцийн зураг*

Өгүүллийн товч утга: *Эл өгүүлэлд монголын эртний нүүдэлчдийн тэнгэр шүтлэгийн бүрэлдэхүүн дэх задын шүтлэг буюу тэнгэр задрааж хур тунадас оруулах эртний зан үйлийг илэрхийлэх тэнгэр задраах, зад барих, зад тавих, түүнчлэн тухайн зан үйлийг үйлдэхүйд үндсэн багаж хэрэгсэл болсон задын чулуу зэрэгт гол хэрэглэгддэг зад хэмээх хэлний дохионы хамгийн бага утгат нэгж болсон язгуур морфемийн гарвал, утгыг шинжлэн үзэж, түүгээр дамжин илрэх эртний нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзлийг илрүүлэхийг зорив.*

Эртний нүүдэлчдийн зад шүтлэг нь тэдний амьжиргааны эх сурвалж болсон байгаль дэлхийн үр өгөөжийг тогтвортой байлгахыг хүссэн бодит шаардлагаас үүдэж үүссэн шүтлэг юм. Тодруулбал ган, зуд зэрэг байгалийн хатуу ширүүн үзэгдлээс шалтгаалж хүн хоол тэжээлийн хомсдол, амьдрах орчны тааламжгүй нөхцөлтэй байнга биш ч ямар нэг давтамж, хэмжээгээр учирдаг байсныг даван туулахын тулд тэр бүхнийг далдын ид хүчний чинадын эх үүтгэгч хэмээн тэнгэрийг сэтгэн төсөөлж, итгэж бишрэн, түүнийг элдэв арга ид шидээр задалж задраан ган гачгийг тайлж хур тундас оруулах хүслээс үүдэлтэй бишрэл шүтлэг юм. Өөрөөр хэлбэл зад хэмээх увдис чанар бүхий эд зүйлийн шид хүчээр байгалийн үзэгдлийг өөрийн хүсэл зоригт нийцүүлэн эерүүлж урвуулахыг эрмэлзсэн хүсэл горьдлого, сүсэг бишрэл бүхий зан үйлийн нийлэг тогтолцоот шид шүтлэг (magico[1]) гэж хэлж болно.

Энэ шүтлэг нь хүн төрөлхтний баларлаг цагийн байгалийн шүтлэгээс эхтэй хийгээд хожим нь тэнгэр шүтлэгт уусан сүлэлдэж боловсронгуй болсон хэмээн үзэж болно. Иймээс энд тодорхойлсон задын шүтлэг нь тэнгэр шүтлэгийн нэг хэлбэр юм. Гэвч тэнгэр нь эхэндээ өдгөөх дээр хөхрөгч гэсэн нэрийн утгаар бус, эрт болоод дундад эртний бурхан гэсэн утгаар ч бус, харин ертөнцийн ай их хүчийг агуулагч гэсэн өвөг утгаар буюу хур бороо, цас мөндрийг агуулагч чинадын орноор төсөөлөгдөж байсан нь задтай холбоотой үг хэллэгийн утгаар илрэх үзэл төсөөллөөр тодорно. Тодруулбал “*тэнгэр задрах”*, “*тэнгэр задраах*” гэсэн үг хэллэгийн утгыг нягтлан шинжилвээс чухамдаа тэнгэрийн наагуур бүрхэвч бүрээс буй хийгээд түүний чинадад энэ газар дэлхий, хүн зонд хэрэгтэй бороо хур агуулагдаж байдаг

---

[1] *Ìàãè* /mageia/ – ýðòíèé ãðåã õýëýýð èä øèä ãýñýí óòãàòàé ¿ã. Õ¿í ÿìàð íýã áàéäëààð áóñàä õ¿ì¿¿ñ, àìüòàí, óðãàìàë áîëîí áàéãàëèéí ¿çýãäýëä íºëººëºõ èä øèäèéí ÷äâàðò èòãýæ áèøðýõ ø¿òëýã.

гэсэн үзэл төсөөлөл, ертөнцийн нэгэн зураг анзаарагдана. Тиймээс тэнгэрийн наадтайх тэрхүү тусгаарлагч бүрхэвчийг задлаж чадваас хур бороо орно гэсэн үзэл төсөөллөөс тэнгэр задраах янз бүрийн арга ухаан, басхүү тэнгэр задраахад гол чухал үүрэг бүхий задын чулуу гэх уг зан үйлийн түлхүүр болсон увдис чадалт багаж зэвсгүүд сэтгэгдэн оюун санаанд зохих байрыг эзэлсэн хэмээн хэлж болно. Энэхүү өнө эртний үзэл төсөөлөл ертөнцийн ерөнхий зураг нь огторгуй хэмээх үгийн утгаар ч басхүү илэрнэ.[2]

“Монголын соёлын түүх”-д “Монголчуудын шүтлэг, мөргөл, утга соёлд нэн түгээмэл тохиолддог “цалиг” хийгээд “цалиг дүр” бол юуны өмнө “Задын чулуу” билээ” (Дулам, 1999: 268).

Нэг: - Зад хэмээх үгийг “Монгол хэлний товч тайлбар толь”-д: **Зад** I бороо хур орох зэргээр тэнгэрийн байдал гэнэт хувирах үзэгдэл; **шувууны зад** (шувуу буцах үеэр орох хур бороо); **задын чулуу** (шинэ чулуун зэвсгийн үлдэц); **зад өвс** ургамал (уул хээрт ургах өвс, төрөл зүйл олон, эртнээс нааш хүн амьтны яс махны шарх гэмтлийг анагаах чадалтай гэж авч хэрэглсээр иржээ). **ieoa** (Цэвэл 1966;256)

“Монгол үгсийн язгуурын толь”-д **ieoa** [jada] бороо хур орох зэргээр тэнгэрийн байдал гэнэт хувирах үзэгдэл; муу цагийг мөн ингэж хэлдэг байжээ. ***зад болох***, **idea** [jada] зуд шуурга гаргах буюу зогсоож чаддаг хэмээх **Yilwk DeI cilegO** - илбэтэй чулуу 2.Салхи бороо урих, зогсоох эрдэм увдис. Түрэгчүүд аль эртнээс хур бороо, зуд шуурга гаргах увдистай гэдэг байсан бөгөөд тэдэнтэй харьцаатай байсан Найман аймгаар дамжиж монголд энэхүү увдис нь нэвтэрч байжээ. МНТ 143§, *“Асар тэнгэрийг задруулаад гурван эхтэй зад татаад, гучин хоёр зүйлийн хүйтэн хар төмөр шуургыг хүйсэн дээр нь эсэ татхул чинь”* (Жангар 12§), “Хур оруулах задын увдис хэмээх оршив” (Хутагт их үүлний мандал хурыг оруулах судар) 3. **IJWeeit** гиван (Сэцэнцогт 1988; 2346-2347)

“Эртний түрэг хэлний толь”-д JAT II (ят, яд яда Ю.Б) салхи, бороо урин дуудахтай холбоотой илбэ, ид шид, увдис (МК III 159; *TT* X_{561})[3], (Наделяев, 1968: 247) *JATČÏ* – увдис шидтэн (задач Ю.Б), JATLA-II – колдовать, заклинать – задлах, *jatčï jatladï* – волшебник произносил заклинания (чтобы вызвать дождь) – задач задлав (МК III 307) (Наделяев, 1968: 247-248).

---

[2] Îãòîðãóé – Ñóäëàà÷èä ýíý ¿ãèéã *îãò-îð-¿ã¿é* ãýæ çàäëàí ñàíñðûí îðîí çàéí ðÿçãààðã¿é óóäàì øèíæèéã èëýðòèéëñýí óòãàòàé ðÿìýýí òàéëáàðëäàãà. Òýãàýë *îãòîðãóéí î¸äîë* ãýæ òýíãýðèéí çàääëûã íýðëýõ íü áóé. Ýíäýýñ áèäíèé ºâºã ñýòãýëãýýíèé ºâºðìºö ä¿ð çóðãèéã ðàðàõ áîëîëöîî ðàðàäàäàæ áàéíà. Ó÷èð íü ãýð áàðèõàä õîéä óðäàõ äýýâðèéã çºð¿¿ëäýã øèã ë îãòîðãóéã íèéë¿¿ëæ î¸æ á¿òýýñýí òóõàé (àðõåòèìèéí ñîíãîãîã íýãýí æèøýý) ¿çýë òºñººëºë óã ¿ãñèéí óòãàãñ èëýðõèé õèéãýýä ýíý íü áèäíèé îðøèõ ñàâ åðòºíöèéí ãàäàãàä õèë õÿçãàãð, õÿëáýð, õýâ øèíæèéã èëýðõèéëæ áàéíà. Ò¿¿í÷ëýí îîíãîë÷óóä òàðâàãûã õóëãàð øàð ãýõýýñ ãàäíà *îãîòîð øàð* ãýæ íýðëýäýã. Ýäãýýð íü ò¿¿íèé ÷èõíèé îíöëîãîîñ ¿¿äñýí áîëîõ íü èëýðõèé õèéãýýä í¿õýíä àìüäðàã÷ æèæèã ìýðýã÷èéã áèä *îãîòîî, õóëãàíà* õýìýýí àíãèëæ íýðëýãäèéí *–qul- áóþó õóë* ãýäýã íü ýðòíèé ò¿ðýã, îîíãîë÷óóäûí ÷èõ ãýñýí ¿ã áºã ºº ä õóëàí ãýäýã íü òîì ÷èõòýé áèò¿¿ òóóðàéòàí (ºãã ºº ÷ çàðèì ãàçàð õóëàíã ÷èõò ãýõ íü áóé) áîë õóëãàíà ãýäýã íü òîì ÷èõòýé ìýðýã÷èéã, õàðèí îãîòîî ãýæ îãîòîð ÷èõòýé ìýðýã÷äèéã ÿëãàí íýðëýæ áàéãàà àæýý. Ýäãýýð *îãîòîð* ÷èõòýé àìüòàäûí ÷èõíèé îíöëîã øèíæ íü þó âý ãýâýë ÷èõ íü æèæèãõýíýýñ ãàäíà õàìãèéí ãîë íü ãàäàà èðìýã õºâºº íü äóãóéëæ *îãòîíëñîí* ìýò àæãóó. Òèéìýýñ *ÎÃÒÎÐÃÓÉ* ãýäýã íü òýíãýðèéí îðíû çàõ õÿçãààðûí õýëáýð, õýâ øèíæèéã çàäñàí óòãàòàé áóþó äîòîð òàëààñ íü èëýðõèéëâýë õ¿íõýð, ãàäíà òàëààñ íü áîë áºìáºãºð (í¿¿äýë÷äèéí ãýð ñóöö áîë ñàíñàð, îãòîðãóéí áè÷èë çàãâàð áîëñîí áýëãýäýë. Òýíãýð îãòîðãóéã èéíõ¿¿ ñýòãýõ íü áèäíèé í¿äýíä õàðàäààõóé ãàäààà åðòºíöèéí åðºíõèé òºðõ áàéäëèààñ ¿¿äñýí õýðýã õèéãýýä òýíãýðèéí õàÿà ãýäýã ¿ã ÷ ãýðòýé èæèëñ¿¿ëæ òºñººëæ áóéí òîä æèøýý þì) õýëáýðòýé áîëîõûã èëýðõèéëæ áàéíà. Ýíý íü õ¿í òºðºëõòíèé îð÷ëîãèéí õýëáýð ä¿õñèéã õºíºðñºí òîãîî ìýò õàãàñ áºìáºãºð áóþó õ¿íõýð õýìýýí òºñººëæ ãàí íèéòëýã ¿çýë òºñººëºèòýé íèéõíý. ×èíãýñíýýð îãòîðãóéãààñ ÷èíàãø áàñõ¿¿ îðîí çàé áóé ãýñýí óõàãààõóóí áàñ èëýðíý.

[3] **ÌÊ** – Ìàõìóä Êàøãàðûí òîëøè – Ýðòíèé ò¿ðýã õýëíèé òîëö (ÝÒÕÒ)-èéã çîõèîõóéä àøèãëàñàí (1072-1074 îíû ¿å) ò¿ðýã àðäûí äóó, ø¿ëýã, ¿ã õýëëýãèéã àðàá õýëíýý îð÷óóëæ òàéëáàðëàñàí 17 ìºðºð áè÷ñýí 638 õóóäàñ á¿õèé ÷óõàë õýðýãëýãäýõ¿¿í áîëñîí òîëö áè÷èã. *Äåâîíó ëóãîòèò òóðê*. Èíäåêñ-ëóãàò. Ã.Àáäðóõìîííâ íà Ñ.Ìóòàëëèáîâèàð èøòèðîêè âà òàõðèðè îñòèäà. Òàøêåíò, 1967; ***ÒÒ-Õ*** – ÝÒÕÕÒ-èéã çîõèîõîã àøèãëàñàí óéãàð áè÷ãèéí äóðñãàëóóäûí íýã. *Àòàâàêà øóëìàñûí òóõàé äîìãèéí* õýñýã. Gabain A., von. Türkische Turfantexte. X. *Das Avadana des Dämons Ätavaka*. Bearbeitet von Tadeusz Kowalski. ADAW, 1958, ¹1

“Перс Орос толь”-д ەدي [iade] *ядэ* - 1) илбэ, увдис; 2) увдист чулуу (хур тунадас урин дуудаж оруулах болон зогсоохуйд хэрэглэдэг чулуу) (Османов, 1983: 743).

Түүнчлэн **зад**ыг казах хэлэнд ***жай, жей;*** *задын чулуу - жайдын тасы;* (Базылхан, 1984: 238), Хиргис ардын “Манас” туульд мөн “***жай***” (Манас 1988: 154), Якут хэлнээ “***сата***” (Малов 1947: 157) гэдэг ажээ. Энэ бүхнээс монголчуудын зад, жад хэмээх үгийг эртний түрэг хэл болоод перс хэлнээ *яд, ят, яда, ядэ* гэж буй нь дундад эртний монгол хэлний *зарлиг* хэмээх үг персээр غيلريـ[űerleg], түргээр *jarliqa*-буюу *ярлика,* энэ нь утга шилжсээр орос хэлнээ хаяг шошго гэсэн утгатай ярлык, мөн хууль гэсэн утгатай ***засаг*** хэмээх үг персээр اساي [yasa], قاساي [yasaγ] - *яса, ясаг,* түргээр *яса* гэх төдийгүй Византийн (Зүүн Ромын эзэнт улс) хаадын ***Юст****иаиы* ***Юст-***, өдгөөх англи хэлний шударга ёс, хууль зүй, шүүх гэсэн утгатай ***justice*** [dzustis]-ийн ***just-***, түүнчлэн бидний хэв хууль гэх, үнэндээ бол ***ёс хууль***-ийн **ёс,** тэрчлэн хүнийг *яв,* нохойг *жав* гэх, Ойрадууд замыг *ям*, цаашилбал оросууд *замчин* гэхийг *ямщик* гэдэг нь монгол хэлнээс дамжсан болох нь илт. Эдгээр жишээдээс үзэхэд үгийн эхний *[j], [z]* авиа нь *Japan* гэхийг *Япон* гэж дуудахын адил *[ya], [yo]* авиагаар сэлгэсэн болох нь тодорхой байна. Дэлхийн олон хэлнээ түгээмэл байх дээрх эгшиг авиа хоорондын сэлгэх үзэгдлийн жишээ болсон бидний гол судлагдахуун ***зад*** хэмээх хэлний дохионы хамгийн бага утгат нэгж болсон энэхүү язгуур морфем нь монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн шүтлэг бишрэлийн нэг хэлбэр болох зад шүтлэгийн гол амин утгыг агуулсан бүтээвэр болох нь эрт болоод дундад эртний дээрх бичгийн сурвалжууд дахь утга, тайлбар сэлтээр илэрч байна. Энэ нь өдгөө Төв Азийн нүүдэлчдийн дотор *жай,* **зах**(а)дууд (**як**утууд) буюу **сах**ачуудад ***сата*** хэлбэртэйгээр хэлэгдэж хэрэглэгдсээр буй ажээ. Харин энд ***зад***-ын эхний *z* буюу *j* авиа нь *s*-ээр сэлгэжээ. Ийнхүү энэ үг эртний перс, түрэг, монгол хэлнээ ижил утгаар хэрэглэгдэж, өдгөө ч утга нь тогтвортой уламжлагдан хадгалагдсаар буй нь бидний энэхүү эртний нүүдэлчдийн задын шүтлэгийн утга агуулга, учир шалтгааныг нээн тодруулахад ихээхэн ач холбогдлыг өгч байна. Гэвч үгийн гарвалын асуудлаар эртний перс, түрэг, монгол алин болохыг энэ судалгаанд магадалсангүй. Хэдийгээр дээр өгүүлсэн Сэцэнцогтын “*Түрэгчүүд аль эртнээс хур бороо, зуд шуурга гаргах увдистай гэдэг байсан бөгөөд тэдэнтэй харьцаатай байсан найман (мөн Ойрад Ю.Б) аймгаар дамжиж монголд энэхүү увдис нь нэвтэрч байжээ*” гэж МНТ-ны 143-р зүйлийн мэдээнд түшиглэн ийнхүү дүгнэх, түүнчлэн дээр өгүүлсэн мэдээ баримтыг агуулсан сурвалж бичгүүдийн нэг хоёр зууны өмнө бичигдсэн дийлэнх эртнийх нь түрэг хэлээр буйд дулдуйдан түргээс монгол хэлнээ нэвтэрсэн хэмээн үзэж болох ч энэ нь баттай нотолгоо болж чадахгүй юм. Юутай ч *зад* хэмээх үг нь эртний түрэг, перс хэлнээ тэнгэрийг задраах увдистай шидэт чулуу болоод тэрхүү увдис үйлийн язгуур болох нь монгол хэлнээ басхүү давтагдаж байна. Түүнчлэн палеолитын эцэст бий болж, неолитын түрүү үеийг хүртэл хэрэглэгдэж байсан бичил чулууны (микролит) соёлын үйлдвэрлэлийн өвөрмөц арга барилыг илэрхийлдэг говийн үлдэц (нуклеус) буюу монголчуудын нэрлэдгээр задын чулуу нь ихэвчлэн байгалийн чулуулгаас хатуу чанараараа хүний хөгжлийн урт удаан хугацааны туршлагаар шалгарч танигдсан цахиурын төрлийн чулуу байдаг хийгээд тэдгээр нь хагачин цуулж, чулуун зэвсэг хийсээр цуулагдахгүй болсон үлдэгдэл цул хэсэг нь юм. Энэхүү цул үлдэгдэл буюу говийн үлдэц цахиурын төрлийн хатуу чулуугаар хийгдсэн атал хус шиг зөөлөн модоор зорж хийгдсэн мэт түүний өвөрмөц зөв хэлбэр нь ажиглаж байхуйд эртний чулуун зэвсгийн соёлтнуудын зэвсэг хийх арга технологийг биширмээр, нөгөөтэйгүүр чулууны эрч хүчний тухай хүн төрөлхтний өвөг үзлээр бол хагарч цуулагдсаар ахин хуваагдахгүй болсон хамгийн

цул үлдэгдэл хэсэгт (атомын цөмийн адил) хамгийн их эрч хүч энерги хадгалагддаг[4] гэхийн учир бидний өвөг нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэлд тэр нь онцгой байр эзэлж, тийнхүү задын чулуу, тэнгэрийн сум хэмээн нэрлэгдэж тэнгэрийг задраах увдис шид хүчийг дотроо агуулсан гэх өвөрмөц шидэт дүр бүхий зэвсэг болжээ.

Монголчуудын задын чулууны хамгийн сонгодог дүр болсон энэхүү говийн үлдэцийг археологийн шинжлэлд үлдэц гэх болсон нь *хамгийн хатуу гол цөм* (pinguitudinis, terrae) гэсэн утгатай *нуклеус – nucleus* (Дворецкий, 1976: 679) хэмээх эртний латин үг хийгээд энэ нь өдгөө зөвхөн археологийн шинжлэлд хэрэглэгдэж буй нэр томъёо бус болох нь атомын цөм *(atomic nucleus)*, цөмийн зэвсэг *(nuclear weapons)*, цөмийн реактор *(nuclear reactor)* гэдгээс мэдэгдэж байна. Гэтэл орос хэлэнд цөм гэхийг *ядро*, атомын цөмийг *ядро атома* гэх хийгээд энэ нь самрын үр, эсийн бөөм, дэлхийн цөм гэхэд хэрэглэгдэхийн зэрэгцээ басхүү сум гэсэн утгатай ажээ. Орос хэлний *ядро* гэсэн энэ үг нь бидний судалгааны эл хэсгийн үр дүнд чухал нөлөө үзүүлж буй нь **нэгдүгээрт:** монголчуудын хагачиж, цуулагдсаар задрахгүй болсон задын чулууны адил цул мөхлөг цөм гэсэн утгынхаа хувьд, **хоёрдугаарт:** уг үгийн эхний үе дэх *яд*- нь дээр өгүүлсэн түрэг болоод перс хэлний *зад*-ыг нэрлэх *яд*-тай адил байгаа явдал бөгөөд энэ нь сонирхолтой тохиолдол бус харин монголчуудын задын чулуу хэмээхийн зад гагцхүү тэнгэрийг задраах увдис чанарыг илэрхийлэхийн зэрэгцээ басхүү цул цөм хэсэг гэсэн утгыг агуулсан болохыг харуулж байна. Ийнхүү үзэх нь төрөл бус хэлний үгсийг хамаагүй хамаатуулж буй мэт боловч бороо оруулах увдист чулууны тухай YII зууны сири бичээсэнд "яда" хэмээн тэмдэглэсэн, мөн түрэг, перс хэлнээ "яд", ايدي [iade] "ядэ" хэмээн хэрэглэгдэж байсныг анхаарч үзэх нь зүйтэйн дээр слав хэл, түүний дотор орос хэлнээ олон зуун түрэг үг орсон байдгийг, түүнчлэн Евроази дахины олон өвөг хэлийг нэгэн эхтэй байсан хэмээх нострат хэлний онолын үүднээс үзвэл энэ нь үгүйсгэшгүй хийгээд тохиолдлын бус хэрэг болох билээ.

Энэ бүхнээс *нуклеус-ядро-зад* нь нэг талаар гол цөм гэсэн ижил утгатай, нөгөө талаар асар их эрч хүчний гол эх сурвалж болохынхоо утгаар буюу тэмдэглэгдэхүүнүүдийн контекстийн утгаараа ижилсэж байна. Иймээс задын чулуу гэдгийг цөм чулуу, археологийн шинжлэл дэх үлдэц гэх нэрийг цөм чулуу буюу задын чулуу гэж ойлгож болно. Түүнчлэн цөмийн зэвсэг гэхийг задын зэвсэг гэж нэрлэж болохын зэрэгцээ задлах, цөмлөх, зад цохих, цөм цохих зэрэг нь ч ерөнхий утга ижил ажгуу. Гэвч энэ нь монгол нутаг дахь эртний нүүдэлчид алив юмны, тэр дундаа чулууны эрч хүч гол цөмдөө чинадлагдаж агуулагдана гэсэн үзэл төсөөллийн илрэл болохыг харуулж буйгаас бус тэд тэр цагт атомын цөм хийгээд цөмийн эрчим хүчийг мэдэж төсөөлж байсан гэсэн хэрэг биш ээ. Тиймээс тэнгэрийг задрааж бороо хур болоод тэнгэрийн бусад үзэгдлийг урин дуудан ирүүлж болох тухай задын чулууны энэхүү үзэл төсөөлөлд гагц түүний цул цөм шинжээс гадна

---

[4] Èéíõ¿¿ ÷óëóóã ýð÷ õ¿÷òýé ãýõ öàëèã÷èëñàí ¿çýë íü õ¿íèé õºãæëèéí íýí ýðò ¿åýñ õàòóó ÷àíàðòàé ìàòåðèàëàòð áàãàæ çýâñýã õèéõèéã ýðýëõèéëæ, îëîí çóóí ìýíãàíûã ¿çýæ òóóëàõ ÿâõàä òóðøëàãàä òóëãóóðëàæ òºëºåøñºí ¿çýë õèéãýýä ñàéí ÷àíàðòàé áàãàæ çýâñýãòýé áàéíà ãýäýã õ¿÷òýé áàéõûã, ýñðýãö¿¿ëæ õýëáýé õàòóó ÷àíàð äèéëäýøãã¿é õ¿÷ ÷àäëûí èëýðõèéëýé áîëæ òºñººëºãäñºíèé ¿ð ä¿í áîëîí. ¯¿íèé òîã íîòîëãîî íü õ¿í òºðºëõòºí àëìàñ ýðäýíèéã ÷óëóóíû õààí õýìýýí õàìàãàñ ýðõýìä ¿çýõ ÿâãàë áîëîí. ×óëóóíû ýð÷ õ¿÷íèé òóõàé ýë ¿çèèéã ãýð÷ëýõ îëîí àðâàí òîã æèøýýã áèä ¿ëãýð, ãîìàîîñ îëîõ áîëîìæòîé áà íàää çàõ íü îíîãîë àðãûí áàäàòàðëàã òóóëüñò õºøºº ÷óëóóí ç¿õõòýé Õ¿âýé Áóéäàð õ¿¿ãèéí àäèë õ¿ðýë ÷óëóóí áîëîîã õàð ÷óëóóí ç¿õõòýé áàòàðóóä âàðàõ áà ìºí áººãèéí äóóäëèãàä "Õ¿ðýë ÷óëóóí ç¿õõòýíã¿¿ã" õýìýýí ºã¿¿ëýãääýã íü õ¿íèé áèå ìàðáîäûí àìüäàð÷ îðøèõóéí ¿íãñýí ãîë ýðõòýí õýìýýí ¿çýõ ç¿õõèéã (*ýíý íü áàñ çîðèàèéã àãóóëäàã õýìýýí ¿çäýã ó÷èð "ç¿õõ çîðèã" õýìýýí õîðøèæ õýðýãëýäýã áà çîðèã* ***ioriea*** *íü ç¿õõ* ***iiroHt*** *ãýäãýýñ ñàëáàðèæ ¿¿ññýí ¿ã àæýý*) áàñõ¿¿ ýð ÷ãàäë, ýð÷ õ¿÷íèé áýëãýäýë áîëñîí ÷óëóó áîëîí õ¿ðýë ÷óëóóãààð á¿òñýí ãýõ íü òóóëüñûí áàòàðóóäûí òóéëûí àóãàà äèéëäýøãã¿é õ¿÷òýé áîëîõûã ç¿éðëýí èëýðõèéëñíèé æèøýý þì.

түүний дүрс хэлбэрийн гайхамшигтай өвөрмөц шинж нь тийнхүү төсөөлж цалигчлахын гол чухал хүчин зүйл болсон тухай дээр өгүүлснийг энд ахин дурдах нь зүйтэй юм.

Хоёр: - Хаш чулууны нэгэн төрөл болох ногоон хашийг байгалийн шинжлэлд "Нефрит" гэдэг. Энэ нь эртний грек хэлний "nephros" буюу бөөр гэсэн утгатай үгээс үүдэлтэй бөгөөд барууны орнуудад уг чулууг бас **"*Jade*"** гэж нэрлэдэг. Чингэхдээ уг нэр басхүү "увидаст чулуу" гэсэн язгуур утгыг агуулсаар буй нь сонирхолтой хийгээд энэ нь өгүүлэн буй сэдэвт шууд холбогдоно. **"*Jade*"** нь эртний грек, латин сурвалж бичгүүдэд тэмдэглэгдээгүй болох нь тэдгээр хэлний толь бичгүүдээс үзэхэд илт. Учир иймд үгийн гарвалын хувьд Европын хэлнүүдийн унаган бус харин зээлдмэл үг болов уу. Юутай ч уг чулууг хятадууд "пийсүү" гэх бөгөөд тэдний хувьд уг чулуу нь бороо хур оруулах задын увидаст гол чулуу байдаг. Тэгээд ч түүгээр олон төрлийн гоёлын зүйлсийг сийлбэрлэн урласаар ирсэн уламжлалтай билээ. Ер нь ногоон хаш хүн төрөлхтний чулуун зэвсгийн үе дэх багаж зэвсгийн нэгэн чухал түүхий эд болж байв. Үүнийг манай орноос олдсон чулуун зэвсгийн дурсгалуудаас ч харж болно. Харин энэ чулууг Европын хэлнүүдэд яагаад **"*Jade*"** гэх болсон тухайд бол XIII зууны үеийн Монголын эзэнт гүрэн, түүний дараах Монголын хаант улсуудын (XIII-XIY зуун) түүхтэй холбоотой болов уу. Дэлгэрүүлбэл, *Fax Mongolica* буюу *Монголын энхжин* тогтнож асан цагт өрнө дорныг холбосон худалдааны торгон замаар өрнө зүгт тээгдсэн эд зүйлсийн дотор хятад газар хийгдсэн ногоон хашин гоёлын зүйлсийг тээвэрлэн хүргэж худалдаалагсад уг чулууг хятадаар бус харин тухайн эрин цагийг эзэгнэн манлайлж байсан монголын нүүдэлчдийн нэрлэдээр нэрлэж түгээсэн байх магадлалтай юм. Гэхдээ "*Jade*" нь тухайн гоёлын зүйлсийг хийсэн чулууны ерөнхий нэр байж, басхүү увидастай гэх утгыг агуулж байсан нь эзэндээ ээлтэй гэсэн бэлгэдлээр эерэгжин суртчилагдаж байсан болов уу.

Гурав: - Мөн зад хэмээх үгээс үүссэн (Өвөрлөгч монголчуудын олонх *зад*-ыг *жад* хэмээн дуудна) нэгэн нэр бол монголчуудын уламжлалт зэр зэвсгийн дотор жад **Jida** [jida] нэртэй "болдоор хийсэн хурц үзүүртэй хатгах зэвсэг" (Цэвэл, 1966) бөгөөд энэ нь хэлбэр дүрсийн хувьд задын сонгодог зэвсэг болох задын чулуутай (амьтны гарвалт гиван бус) ижил хурц шовх үзүүртэйн дээр дайсны бие эрхтнийг хатгаж задлах үүрэгтэй учир тийнхүү утга шилжин нэрлэгдсэн ажээ. Жадны нэгэн өвөрмөц төрөл нь тугны жад бөгөөд монголчуудын есөн хөлт цагаан, дөрвөн хөлт хар сүлд зэрэг бусад эртний уламжлалт тугууд бүгд оройдоо жадтай байдаг. Үүний гол бэлгэдэл утга нь дайсны сүр сүлдийг цаг үргэлжид дарж, өөрсдийн сүлд хийморийг бадрааж байх явдал бөгөөд үүнийг гүйцэлдүүлэх гол хүч нь задын чулууны адил тэрхүү жаданд агуулагдах далд увдис, шид хүч юм. Энэ нь тугийг сүлд хэмээн амьдчилан үзэх цогц үзэл, шүтлэгийн чухал бүрэлдэхүүн нь болно.

Дөрөв: -Түүнчлэн жилийн дөрвөн улирал ээлжлэн мал маллан нүүдэллэн амьдрах монголчуудын хувьд байгаль цаг уурын хатуу ширүүн үзэгдлүүд, тэдгээрийн аж ахуйд, түүгээр дамжин нүүдэлчний амьжиргаанд нөлөөлөх нөлөөллийг илэрхийлсэн зарим үг, хэллэг зад хэмээх үгтэй холбоотой байгаа нь монголын эртний нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзлийг тодруулах боломжийг бидэнд өгч байна. Үүнд нүүдэлчин монголчууд бид байгаль, цаг уурын хатуу ширүүн, гамшигт нэгэн үзэгдлийг ***зуд*** *[zud]* хэмээн нэрлэдэг. Зуд хэмээх энэ нэрийг шинжвэл зад хэмээх үгээс эгшиг авиа хувирч үүссэн нэр болох нь тод харагдана. Тэгвэл зуд гэдэг нь өвөг нүүдэлчдийн сэтгэлгээгээр бол тэнгэрийн хилэгнэж задарсан буюу тэнгэр өөрөө хүмүүний ахуй ертөнцөд задлаж (зад тавьж), их хэмжээний цас оруулсан (цагаан

зуд), эсвээс тунадас оруулаагүйн үр дагавар (хар зуд) болсон үзэгдлийг заасан нэр ажгуу. Иймд өвлийн улирал дахь тэнгэр бурхны задын үр дагавар нь зуд хэмээх үзэгдэл гэж ойлгох нь зүйтэй юм. Тиймээс ч эрдэмтэн Л.Түдэв нэгэн эссегээ “Задын чулуу зуд урина” (Түдэв, 1998) гэсэн нь хэдийгээр уг эссенд эл үгийн гарвалын талаар дэлгэрэнгүй тайлбар хийгээгүй ч гэсэн харин дээрх гарчиг нэрээрээ энэ саналыг илэрхийлсэн байна. Түүнчлэн зудаас болж хүн мал зутарч зүдэрдэг. Зутрах, зүдрэх хэмээх үгсийн *зут-[zut-]*, *зүд-[zűd-]* хэмээх үндсийн утга, дуудлагын ижил шинжийг нь нягталбал дээрх зудаас үүдэлтэй, түүний үр дагавар болсон үзэгдлийг илэрхийлсэн байна. Чингэвэл тэнгэрийн задрал буюу *зад*-ын газар дэлхий дээрх үр дагавар болсон үзэгдлийн нэр нь *зуд*, энэ нь хүн малыг *зут*-раадаг, *зүд*-рээдгээр барахгүй хүнийг *яд*-ууруулж ядуу болгодог гэсэн байгаль цаг уурын үзэгдэл, түүний хувирал өөрчлөлт, хүний ахуй дахь нөлөөлөл гэсэн логик хамаарлыг өвөг монголчууд танин мэдсэний үндсэн дээр эдгээр үгс утга шилжин буй болжээ. Тэгвэл ядуу гэдэг үг нь *зут*-, *зүд*-ийн адил *зад* язгуураас үүссэн нэр болно. Тиймээс ч монголчууд бид *ядуу зүдүү* гэж хоршиж хэрэглэсээр авай. Ядуу хүн гэдэг нь арчаагүй, залхуу учраас л тийнхүү ядуу байгаа гэж өнөө цагийнхны үзэх нь буй. Гэтэл бидний өвөг сэтгэлгээгээр бол тийм бус, харин тэнгэр түүнийг таалахгүй байгаагаас үүдэж л тэрвээр ядуу байгаа юм гэсэн далд утгыг *яд* - гэсэн уг язгуур чинадлаж байна. Энэ нь алив хүний сайн сайхан амьдрах эсэхийг гагц тэнгэр бурхан л мэднэ гэсэн нүүдэлчдийн уламжлалт тэнгэр үзэл буюу тэнгэризмд зохирно. Нөгөөтэйгүүр эдгээр үгсийн гарваль, илэрхийлэх утгын холбогдол нь малчин нүүдэлчин монголчуудын аж ахуй, амьдрал байгалаас шууд хамааралтай болохыг илэрхийлэх ажгуу.

НОМ ЗҮЙ

Базылхан Б., 1984. Монгол казах толь, Улаанбаатар-Өлгий

Дворецкий И.Х., 1976. Латинско-Русский словарь, М.

Дулам С., 1999. Эртний шүтлэг. Монголын соёлын түүх, I боть, YI бүлэг, УБ

Малов С.Е., 1947. Шаманский камень яда у тюрков западного Китая. Советская этнография, ¹1, с.151-160

Манас, 1988. Хиргис ардын тууль (орос хэлнээс орчуулсан Б.Энэбиш), УБ

Наделяев В.М., Насилов Д.М., Тенышев Э.Р., Щербак А.М., 1968. Древнетюркский словарь, Л., Наука.

Османов М.Н., Дорри Б.Х., Киселева Л.М., Сарычев С.С., Еремина К.Н., Долимова Б.А., Алиев Г.Ю., 1983. Персидско-Русский словарь, М.

Сэцэнцогт, 1988. Монгол үгсийн язгуурын толь. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, Жанчхүү

Түдэв Л., 1999. Задын чулуу зуд урина. Үгсийн уурхай, УБ, х.60-62

Цэвэл Я., 1966. Монгол хэлний товч тайлбар толь, УБ

SUMMARY

THE ETHYMOLOGY OF THE TERM *JADA* AND PRIMAL WORLDVIEW OF NOMADS

Yu.Boldbaatar

The *jada* stone and other items stand among the objects of *jada* worship, closely related to the worship of Tengri spread among the ancient nomads of Mongolia. A number of household– and warfare-related rituals have endured among Mongols, such as for calling upon a deluge or storm – all of which bearing the Mongol root *jada.* The paper aims to research the origins and etymology of the Mongol term *jada* (equivalent to Turkic *yada*-) and to reveal the primal worldview of nomads.